

ХҮНИЙ НӨӨЦ

- Цэцэрлэгийн бүтэц бүрэлдэхүүн нийт 28.5 ажиллагсадтай үүнээс эрхлэгч 1, арга зүйч 1, ня-бо 1, багш 8, туслах багш 7, нярав 1, тогооч 3, үйлчлэгч 1, угаагч 1, жижүүр 4, эмч 0,5 гэрээгээр ажилладаг.
- Нийт багш нар 100% нь бакалавр, магистрын боловсролтой
- Эрхлэгч Зөвлөх зэрэгтэй, нийт багш нарын 75% нь мэргэжлийн зөвлөх ,тэргүүлэх ,заах аргач зэрэгтэй
- Туслах багш нар 100% сургалтанд хамрагдсан
- Туслах багш нарын 28,5% нь дээд боловсролтой , 71,5% нь бүрэн дунд боловсролтой
- Тогооч нярав 100 % мэргэжлийн

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ГОЛ ЧИГЛЭЛҮҮД

1. Чанартай сургалт, чадварлаг багш
2. Хүртээмжтэй үйлчилгээ, халамжтай эцэг эх
3. Эрүүл биед саруул ухаан
4. Ээлтэй орчин, эрх зүйт хандлага
5. Нийгмийн түншлэл, үр ашигтай менежмент
6. Гэр бүлийн оролцоо, шүтэлцээт хариуцлага

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

- ✓ Сургалт хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулж, арга зүйг хөгжүүлэхийн тулд багшийн тасралтгүй хөгжлийг хангана.
- ✓ СӨБ-ын хамран сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж тойргийн хүүхдийг 100% хамрахын тулд ердийн болон хувилбарт сургалтуудыг хэрэгжүүлж, СӨНХ-ийг цэцэрлэгт хамруулах ажилд эцэг эхийн халамж анхаарал оролцоог нэмэгдүүлнэ .
- ✓ Багш ажиллагсадын болон хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах талаар анхаарч жил бүр эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан орон тооны эмч ажиллуулж, хүүхдийг өвчлөлөөс сэргийлэх ажлыг өргөн хүрээгээр зохион байгуулна.
- ✓ Хүүхдэд ээлтэй, тэдний хэрэгцээ сонирхлыг хангасан стандартын шаардлагад нийцсэн орчинг бүрдүүлж, хүүхдийн эрхийг зөрчихгүй байхад анхааран ажиллана.
- ✓ СӨБ-ын хөгжилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж үр ашигтай, чанартай олон хувилбартай үйл ажиллагааг нэвтрүүлнэ.
- ✓ Эцэг эх гэр бүлийн гишүүдийн оролцоог хангаж тэдний үүрэг хариуцлагыг ухамсаруулах сургалт сурталчилгаа, сонирхолтой олон хувилбартай ажлуудыг зохион байгуулна.
- ✓ Боловсролд тэгш хамран сургахыг дэмжиж төсөлт хөтөлбөр хэрэгжүүлнэ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЛАВЛАГАА

Хүснэгт 1

| | | |
|----|---|--|
| 1 | Аймаг сум, дүүрэг: | Дундговь аймаг Сайнцагаан сум |
| 2 | СӨБ-ын байгууллагын нэр | 3-р цэцэрлэг |
| 3 | Хэдэн онд байгуулагдсан | 1968 онд Мандалговийн төвд |
| 4 | Үүсгэн байгуулагч | Мандалговь хотын АДХГЗахиргаа |
| 5 | Цэцэрлэгийн байршил | Сайнцагаан сумын зүүн дүүрэг, 7-р баг, Буянннэмэхийн өргөн чөлөө, хүнсний 112-р байр |
| 6 | Хаяг | Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р цэцэрлэг |
| 7 | Утас | 70592123 |
| 8 | Цэцэрлэгийн онцлог | 2-5 насны хүүхдэд СӨБ олгох |
| 9 | Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар | 870001030 |
| 10 | Тусгай зөвшөөрөл авсан огноо | 2005.3.18 өдөр |
| 11 | Тусгай зөвшөөрөл олгосн байгуулага, албан тушаалтан | Дундговь аймгийн БШУГ |
| 12 | Цэцэрлэгийн хүчин чадал | 160 |
| 13 | Бүлгийн тоо | 7 |
| 14 | Тойргийн хүүхдийн тоо | 274 |
| 15 | Бүртгэгдэн хамрагдаж байгаа хүүхдийн тоо | 274 |
| 16 | Багш нарын тоо | 8 |
| 17 | Зэрэгтэй багшийн тоо | 6 |
| 18 | Нийт багш ажилчдын тоо | 29 |

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН СУДАЛГАА

| Барилга зориулалт | Ашиглалтанд орсон он сар өдөр | Хүчин чадал | Барилгын чанар | Халаалтын хэлбэр | | Халаалтын систем тавиулах саналтай эсэх | Их засварт орсон он | Одоо ашиглагдаж буй | Түрээсэлсэн | | Халаалтын эзэлхүүн |
|-------------------|-------------------------------|-------------|----------------|------------------|--------------------|---|---|---------------------|------------------|---------------------|--------------------|
| | | | | Ердийн галлагаа | Нэгдсэн халаалтаас | | | | Анги өрөөний тоо | Анги өрөөний талбай | |
| Хүүхдийн цэцэрлэг | 1985.12.5 | 160 | Дунд | - | + | - | 2013 /76 сая төг , БСШУЯ –аас барилгын дотор засал / | + | - | - | 3200 |
| | | | | | | | 2021 / Японы өвсний үндэс төслөөс 659.000.0 төгрөгийн их засвар | | | | |